



МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 10-р сарын 01 өдөр

Дугаар 205


Улаанбаатар хот

Магистрантурт суралцуулах тухай

Өндөр хөгжилтэй орны магистрантурт суралцагчдыг сонгон шалгаруулах санхүүжүүлэх, санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах ажлыг хариуцсан комиссын 1999 оны 7 дугаар сарын 8-ны тэмдэглэл, Захиалагч яам, газруудын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1.1999-2000 оны хичээлийн жилээс эхлэн Лайлангийн Тунгалагийг үйлдвэрлэлийн удирдлагын, Шаандарын Нямтулгыг компьютерийн мэргэжлээр АНУ-ын Колорадагийн их сургуулийн, Шархүүгийн Алтанбадралыг биотехнологийн мэргэжлээр АНУ-ын Пүрдүгийн их сургуулийн магистрантурт тус бүр 2 жилийн хугацаатай, Ухнаагийн Дамдиндашийг мэдээлэл зүйн, Адъяагийн Ичинхорлоог олон улсын худалдааны, Мишигийн Энхбаярыг олон улсын хууль зүйн, Мишигдоржийн Одонтуяаг боловсролын удирдлагын, Нацагдоржийн Диймааг хот байгуулалтын төлөвлөлтийн, Гомбожавын Ариунбуянг бизнесийн удирдлагын, Лхайжавын Сарангэрэлийг эрх зүйн мэргэжлээр ХБНГУ-ын их, дээд сургуулиудын магистрантурт тус бүр 3 жилийн хугацаатай суралцуулсугай.

2.Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулан холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Мөнхжаргал/-д тус тус даалгасугай.

ГЭГЭЭРЛИЙН САЙД  А.БАТТӨР